


ХИМИЙН ХОРДЛОГЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН 7 ХОНОГИЙН МЭДЭЭ


НЭГ. Угаарын хийн цочмог хордлогын мэдээ

Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн Хор судлал, шуурхай удирдлагын албанд 2024 оны 12 дугаар сарын 29-ний өдрөөс 2025 оны өдрөөс 05 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар буюу **эпидемиологийн 1-19 дугаар долоо хоногт** нийт Нийслэлийн 7 дүүрэг, 6 аймагт **1172** хүн угаарын хийн хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан.



Угаарын хийн хордлогод өртсөн иргэдийг байршлаар авч үзвэл:

Угаарын хийн хордлогод өртсөн 1172 тохиолдлын 94% /1102/ нь Улаанбаатар хотод бүртгэгдсэн бол, 6% /70/ нь орон нутагт (Баян-Өлгий /30/, Дорнод /3/, Орхон /11/, Өмнөговь /1/, Сэлэнгэ /6/, Төв/16/, Дорноговь /2/, Баянхонгор /1/) бүртгэгдсэн байна.



Нийслэлд угаарын хийн хордлогод өртсөн тохиолдлыг дүүрэг тус бүрээр авч үзвэл хамгийн өндөр буюу 325 тохиолдол Сонгинохайрхан дүүрэгт бүртгэгдсэн байна.

ЭПИДЕМИОЛОГИЙН **19** ДУГААР ДОЛОО ХОНОГТ

(2025.05.04 – 05.10)

2025 оны эпидемиологийн 19 дугаар долоо хоногт угаарын хийн хордлогын **26** тохиолдол бүртгэгдэж, өмнөх оны мөн үеэс 72%-иар, сүүлийн 5 жилийн дунджаас тус тус 58%-иар тус тус буурсан үзүүлэлттэй байна.




ХОЁР. Бусад химийн бодисын цочмог хордлогын мэдээ

Цэргийн төв эмнэлгийн харьяа Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд **эпидемиологийн 1-19 дугаар долоо хоногт нийт 339** иргэн химийн цочмог хордлогын улмаас эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна.


173Эмнэлгийн
тусламж авч буцсан**166**Хэвтэн эмчлүүлж
эдгэрч гарсан**0**

Нас барсан

Эрэгтэй
46%Эмэгтэй
54%

Химийн хордлогыг насны бүлгээр авч үзвэл 0-9 буюу бага насны хүүхдүүд хамгийн их хордлогод өртөж байна.

2025 оны **эпидемиологийн 19 дугаар долоо хоногт** химийн цочмог хордлогод өртсөн **12** хүн хандаж эмнэлгийн тусламж үйлчилгээ авсан байна. Энэ үзүүлэлт нь өмнөх оны мөн үеэс 70%-аар буурч, сүүлийн 5 жилийн дунджаас 9%-аар тус тус буурсан үзүүлэлттэй байна.



Хүснэгт 1. Химийн цочмог хордлого, шалтгаанаар (Эпи – 19 долоо хоногт)

№	Шалтгаан (Сэдэл)	Санаатай	Санамсаргүй	Нийт
1	Химийн бодисын хордлого	1	6	7
2	Эмийн хордлого	5	0	5
Нийт		6	6	12

Тухайн долоо хоногт химийн бодисын хордлогод **санаатайгаар** өртсөн тохиолдлуудыг авч үзвэл 16-43 насны эмэгтэйчүүд (75%) байна. **Санамсаргүйгээр** өртсөн тохиолдлуудыг шалтгаанаар авч үзвэл 2-30 насныхан байгаа бөгөөд цавуу, үзэгний бэх зэрэг бичиг хэрэгслийн бүтээгдэхүүнүүд болон ахуйн газ, гидрийн шингэн зэрэг бүтээгдэхүүнүүдэд хордсон байна.